



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№118 /562/

2023.08.01

Цаг үе, үйл явдал

МЦНХ-НООС "ТУНГАЛАГ МЭЛМИЙ" ХҮМҮҮНЛЭГИЙН АЖИЛЛАГААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



"Монгол Цэргийн Нэгдсэн Холбоо" төрийн бус байгууллага нь монголын ард түмний сайн сайхны төлөө иргэд, ахмад дайчид, ахмадууд, тэдний гэр бүлийнхэнд төдийгүй иргэний нийгэмд чиглэсэн олон арван бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлж, тэдний талархлыг хүлээсээр байна.

Эдгээр ажлын нэг нь энэ оны 7 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Орхон болон Хөвсгөл аймагт хэрэгжүүлсэн "Тунгалаг мэлмий" сайн дурын хүмүүнлэгийн ажиллагаа билээ.

Тодруулах аваас, МЦНХ-ны удирдлагын урилгаар БНСУ-ын Нүдний шилний нийгэмлэгийн мэргэжилтнүүд манай эх оронд 2 дахь жилдээ ирж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчид, ахмадууд, тэдний гэр бүлийн гишүүд, зарим иргэдийн нүдний харааг авто рефрактоороор шалгаж, газар дээр нь

харааны болон нарны шилийг үнэ төлбөргүй олгож байсан юм. Мөн зарим тохиолдолд харааны шил нь тохироогүй хүнд БНСУ-д захиалгаар хийлгэн эргэж хүргүүлэх ажлыг хэрэгжүүлсэн нь тэдний талархлыг хүлээсэн бүтээлч ажиллагааны нэг хэсэг нь байлаа.

Уг нийгэмлэгийн мэргэжилтнүүд өнгөрсөн оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс 19-ний өдрүүдэд манай улсын нийслэл хотноо ажиллаж, 3000 хүнийг нүдний харааны оношилгоонд хамруулан харааны болон нарны шилийг газар дээр нь үнэ төлбөргүй олгосон юм.

Тэд энэ жилийн хувьд энэхүү сайн дурын хүмүүнлэгийн үйл ажиллагаагаа өргөтгөн Улаанбаатар хотоос гадна Орхон, Хөвсгөл аймагт ажиллаж, амьдарч буй тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчид, ахмадууд, тэдний гэр бүлийнхэнд Ахмадын хороодоос урьдчилан авсан нэрсийн

дагуу үйлчилгээ үзүүлсэнд талархсан хүн тун олон байв.

Энэ үеэр МЦНХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоогоос тодруулга авсан ба түүний хэлснээр уг хөтөлбөр нь 5 жил үргэлжлэх ба Монгол Цэргийн Нэгдсэн Холбооны удирдлагын зүгээс ирэх онд үзүүлэх хүний тоог нэмэгдүүлэх хүсэлт тавьсныг Солонгосын тал нааштай хүлээн авсан нь бас нэгэн боломж гэдгийг сонордуулъя.

Ийнхүү уг сайн дурын бүтээлч үйл ажиллагааг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, олны талархлыг хүлээсэн БНСУ-ын Нүдний шилний нийгэмлэгийн тэргүүн Сүн Хён Чойл болон тус нийгэмлэгийн мэргэжилтнүүдэд чин сэтгэлийн талархал илэрхийлж, улам их амжилтыг бэлгэдэн өрөөе.

Хурандаа Б.ОТГОНБАЯР



"ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨНӨ ГЭЖ БОДОХООР ГОЁ БАЙНА"



Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн түшиглэн зохион байгуулагдаж байгаа хангай бүсийн аймгуудын "Оюутан цэрэг" сургалтын дайчид 8 дугаар сарын 01-

ний өдөр төлөвлөгөөний дагуу тасгийн буудлагыг амжилттай гүйцэтгэлээ. Буудлагаар байлдагч Б.Доржсамбуу, Д.Пүрэвдорж, Б.Отгонболд, Д.Өсөхбаяр,

Б.Буянням, Л.Одлхагва, байсан ч өнөөдөр бодол, сэтгэлгээ минь өөрчлөгдсөн. Харин ч гүйх, жагсаалаар алхах, сургалт бэлтгэлээсээ эрч хүч авдаг болсон байна" гэсэн бол ШУТИС-ийн оюутан, байлдагч Д.Пүрэвдорж "Спортлоор хичээллэдэг болоод ч тэр үү цэргийн амьдрал анхнаасаа хүнд санагдаагүй. Боксоор хоёр удаа улсын аварга болж байлаа. Цэргийн алба амьдралын их сургууль юм байна гэдгийг бие, сэтгэлээрээ мэдэрч байгаадаа маш их баяртай байна. Тэр дундаа Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн офицер, ахлагчаар заалгаж, тэдний нэгэн эд эс нь болон буцалж яваадаа баяртай байна. Удахгүй Цэргийн тангараг өргөнө гэж бодохоор маш их омогшиж, бас сандарч байна" гэсэн юм.

Энэ үеэр зарим оюутан цэргүүдийн сэтгэгдлийг хуваалцахад АШУИС-ийн оюутан, байлдагч С.Ганбат "Оюутан бид нарт маш том боломж гэж үзээд ямар ч эргэлзээгүй шууд л ирсэн дээ. Гэрийнхэн ч "Эр хүн болж төрсний утга учир нь өөрөө цэргийн албаа хаах шүү дээ" гээд их дэмжсэн. Ирээд удаагүй байхад өглөө эрт босох, гүйх зэрэг нь хэцүү юм шиг санагдаж

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
16	8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,446	3,453
EUR	3,796	3,825
CNY	483	488
RUB	37.90	38.10
JPY	24	24.20
KRW	2.65	2.68

ЗУРХАЙ

2023.08.01 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 15

ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал: Өлзийтэй сайн НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 05.28-20.29 БАРИЛДЛАГА: Түлэх ШҮТЭН БАРИЛДЛАГА: Төрөхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олодох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,650,050

Эдгэрсэн

Нийт: 664,420,565

Нас барсан


Нийт: 6,904,150

Цахим шууданд

ДЭЛХИЙН АВАРГА П.ОРХОН СЕРБИД ӨРСӨЛДӨХ ЭРХЭЭ ӨВӨРТӨЛЛӨӨ



- Эрэгтэй
- 57 кг: Занданбудын Занабазар - 2 дахь удаагаа
 - 61 кг: Нармандахын Наранхүү - 2 дахь удаагаа
 - 65 кг: Төмөр-Очирын Тулга - 4 дэх удаагаа
 - 70 кг: Энхтуяагийн Тэмүүлэн - 2 дахь удаагаа
 - 74 кг: Олонбаярын Сүлдхүү - 2 дахь удаагаа
 - 79 кг: Бат-Эрдэнийн Бямбадорж - 2 дахь удаагаа
 - 86 кг: Бямбасүрэнгийн Бат-Эрдэнэ - 3 дахь удаагаа
 - 92 кг: Ганбаатарын Ганхуяг - 3 дахь удаагаа
 - 97 кг: Балтмөнхийн Бадамдорж - анх удаагаа
 - 125 кг: Мөнхтөрийн Лхагвагэрэл - 3 дахь удаагаа
- Эмэгтэй
- 50 кг: Долгоржавын Отгонжаргал - 3 дахь удаагаа
 - 55 кг: Чинболдын Отгонтуяа - анх удаагаа
 - 57 кг: Бат-Эрдэнийн Эрдэнэсүвд - 2 дахь удаагаа
 - 59 кг: Хүрэлхүүгийн Болортуяа - 3 дахь удаагаа
 - 62 кг: Пүрэвдоржийн Орхон - 2 дахь удаагаа
 - 65 кг: Түвшинжаргалын Энхжин - 2 дахь удаагаа
 - 68 кг: Энхсайханы Дэлгэрмаа - 3 дахь удаагаа
 - 72 кг: Энх-Амарын Даваанасан - 3 дахь удаагаа
 - 76 кг: Найгалсүрэнгийн Загардулам - 2 дахь удаагаа




"Белград-2023" чөлөөт бөхийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (ДАШТ)-д оролцох тамирчдын сорил барилдаан өчигдөр (2023.07.30) "Бөхийн өргөө"-нд боллоо.

Эмэгтэйчүүдийн 53 кг-ын жинд явуулах Гавьяат тамирчин Б.Болортуяа, ОУХМ Г.Отгонжаргал нарын халз барилдааныг тодорхой шалтгааны улмаас ДАШТ-ий цугларалт дээр зохион байгуулахаар болсон аж.

Бусад жинд дараах бөхчүүд ДАШТ-д өрсөлдөхөөр шалгарлаа. 2023 оны бөхийн чөлөөт, сонгомол барилдааны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн есдүгээр сард Сербийн нийслэл Белград хотод болно.

Сорил тэмцээнээс ДАШТ-д оролцохоор шалгарсан бөхчүүдийг танилцуулъя.

Гэрэл зураг түүх өгүүлнэ



"ЭХ ОРНОО БИ ИЖИЙГЭЭ ГЭЖ БОДДОГ"
Хурандаа Генерал С.Лувсангомбо

ШҮХЭРЧИН ДАЙЧИД ЗУНЫ СУРГАЛТ, ДАДЛАГЫН БУУЛТАА ХИЙВ



Сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн шүхэрчин дайчид 2023 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Архангай аймгийн Өгийнуур сумын районд зуны шүхрийн сургалт, дадлагын буултыг амжилттай зохион байгууллаа.

Энэ жилийн сургалт, дадлагад шүхэрчин дайчдын эгнээнд Зэвсэгт хүчний анги, байгууллагуудаас 27 цэргийн алба хаагч хамрагдан шүхэр десантын 3 дугаар зэргийн болзлыг хангав. Тэдний дундаас Зэвсэгт хүчний 084, 189 дүгээр ангийн дэслэгч Э.Номин, ахмад Б.Хишигсүрэн нар эмэгтэй шүхэрчдийн тоог нэмэгдүүллээ.

Мөн нислэг, буултыг зохион байгуулж явуулах шүхрийн зааварлагч, онгоцноос гаргагч-тооцоологч 9 цэргийн алба хаагчийг "Шүхрийн зааварлагч"-ийн эгнээнд нэмэгдүүлснээс тус ангийн ахмад М.Долгорсүрэн нь анхны эмэгтэй шүхрийн зааварлагч болсон нь бидний бахархал юм.

Энэхүү сургалт, дадлагын үеэр шүхэрчдийн дадлага, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор шүхрийн төрөл бүрийн тэмцээн уралдааныг зохион байгуулснаас гадна ахмад үеийн шүхэрчид, "Десант бамбар" клубын сурагчид оролцсон гурван үеийн уулзалтыг зохион байгуулсан нь өндөр үр дүнтэй ажил болов.

Дэд хурандаа С.ТЭМҮҮЛЭНЗАЯА



Уриалга



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас "НЭГ ЗАМ-НЭГ СОЁЛ" нөлөөллийн аяны хүрээнд тодорхой ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийт замын хөдөлгөөнд оролцогч, зорчигч та бүхнийг ямар ч нөхцөлд анхаарал, сонор сэрэмжтэй байж өөрийгөө болон бусдыг болзошгүй эрсдэлээс хамгаалахыг уриалж байна.